

-НҮБ, түүний системийн байгууллагуудад хуримтлагдсан мэдээлэл, судалгаа шинжилгээний материалуудаас ашиглах, тухайлбал гадаад өрийн асуудал, хүүхэд, эмэгтэйчүүдийн нийгмийн байдлыг сайжруулах зэрэг салбарт оновчтой ашиглах арга олох.

-Монгол Улсын зэвсэгт хүчин НҮБ-ын энхийг сахиулах хүчний байлдааны бус үйл ажиллагаанд оролцох боломжийн талаар судалж дүгнэлт гаргах.

-ЮНИТАР болон НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран Монгол Улсын хөгжлийн тулгамдсан зарим асуудлаар олон улсын семинар, симпозиум зохиох боломжийг судлах, тухайлбал Монгол Улсын шинэчлэлийн асуудлаар үндэсний симпозиум 1995 он зохиох боломжийг судлах.

**МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН  
ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ  
/1994 оны эхний хагас жил/**

**1994.01.01.** Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат, Ерөнхий сайд П. Жасрай нар Кубын үндэсний баярыг тохиолдуулан Бүгд Найрамдах Куба Улсын Төрийн Зөвлөлийн дарга, Засгийн газрын тэргүүн Фидель Кастро Руст баяр хүргэсэн цахилгаан утас илгээв.

**1994.01.11.** Японы Омияа хотод болсон үзэсгэлэнд оролцсон Монголын зураач Ж. Саруулбуян, С. Цогтбаяр нарын бүтээлүүд “Японы шилдэг зургууд” номд хэвлэгдсэн байна.

**1994.01.12.** Японы монголч эрдэмтэн Т. Мацуда Монголын зохиолчдын эвлэлийн 65 жилийн ойг тохиолдуулан баярын цахилгаан утас ирүүлжээ. Тэрбээр Монголын уран зохиолын хөгжилтөд амжилт хүсээд яруу найргийн “Болор цом-94” наадамд түрүүлсэн шүлэгчийг Японд долоо хоногийн хугацаатай жуулчлуулахаар амлав.

**1994.01.14.** Монгол, Японы хамтын нөхөрлөлийн хөдөлгөөн Хууль зүйн яаманд бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ авав.

**1994.01.18.** Хоёр орны харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийн дагуу Японы Гадаад хэргийн яам жил бүр Монголоос 35 хүртэл насны залуу албан хаагчдыг урьдаг болжээ.

**1994.01.19.** Зураач Д. Гунгаа, С. Энх-Амгалан нарын бие даасан үзэсгэлэн Италийн Милан хотноо нээгджээ.

**1994. 01. 25.** ОХУ, Монгол Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээнд гарын үсэг зурсны нэг жилийн ойг тохиолдуулан ОХУ-ын Ерөнхийлөгч Б. Н. Ельцин Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад илгээлт ирүүлжээ.

**1994. 01. 27.** Хүн амын бодлого, хөндөлмөрийн яамны Тамгын газрын дарга С.Банзрагч тэргүүтэй төлөөлөгчид 1994 оны хамтын ажиллагааны хүрээнд Японы Хөдөлмөрийн институтийн урилгаар Токио орохоор мордов. Италийн Засгийн газраас Монголд ирүүлж байгаа хүмүүнлэг тусламжийн шугамаар 1992 тонн гурил, 900 тонн цагаан будаа илгээжээ.

**1994. 01. 29.** МЗХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Я.Санжмятав тэргүүтэй МЗХ-ны төлөөлөгчид Азийн Залуучуудын зөвлөлийн хуралдаан, Ази, Номхон далайн орнуудын залуучуудын бага хуралд оролцохоор Токио хотыг зорилоо.

**1994. 01. 29.** АНУ-ын Ерөнхийлөгч Билл Клинтонгоос Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбатад цахилгаан утас ирүүлжээ. Уг цахилгаан утсанд Монгол Улс Америкийн Нэгдсэн Улстай энх тайван, аюулгүй байдал, гадаад бодлогын асуудлаар зөвлөлдөх сонирхолтой байгааг илэрхийлсэн Таны захидлыг талархалтайгаар хүлээж авлаа. Таны дэвшүүлсэн саналд нааштай хариу өгч байгаадаа миний бие баяртай байна гэжээ.

АНУ-ын Засгийн гараас манай улсын эрчим хүчний салбарыг дэмжих төслийн дагуу Америкийн Олон улсын хөгжлийн агентлагаас яаралтай үзүүлж буй долоон сая ам. долларын тусламжийн гэрээнд эрчим хүч, геологи, уул уурхайн сайд Б. Жигжид, АНУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дональд Жонсон нар гарын үсэг зурав.

**1994. 02. 02.** Гурван улсын хилийн уулзваруудын цэгийг тодорхойлох тухай Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол Улсын Гадаад харилцааны тэргүүн Дэд сайд Ж. Чойнхор, ОХУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд С. С. Разов, БНХАУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Пэй Зян нар Улаанбаатар хотноо гарын үсэг зурав.

Япон улсын Нагано мужийн Мацумото хотын иргэн Умеки Седзи хэсэг нөхдөө уриалан Монгол, Японы нөхөрлөлийн нийгэмлэг байгуулав.

**1994. 02. 04.** Сангийн сайд Д. Даваасамбуу Японд айлчлахаар мордов.

**1994. 02. 05.** Бүгд Найрамдах Индонез Улсаас тус улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Рахмат Витулар Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбатад итгэмжлэх жуух бичгээ барив.

**1994. 02. 08.** Францын ГЯЯ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Б. Дюфурк Монгол Улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Х. Бэхбаттай уулзах үеэр Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусыг Франц хүндэтгэн дэмжихээ албан ёсоор илэрхийлсэн нот бичиг гардуулав.

**1994. 02. 17.** Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас тус улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Корнэлиус Мэттерних Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбатад итгэмжлэх жуух бичгээ барив.

**1994. 02. 21.** Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Б. Түмэн Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Лех Валенсад итгэмжлэх жуух бичгээ барив.

**1994. 02. 22.** Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхийлөгч Ш. Д. Шарма, Тайландын Вант Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгч Нухак Пумсван, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын дарга Ле Дык Анийн урилгаар Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат гэргийн хамт Азийн дээрх орнуудад албан ёсны айлчлал хийхээр Улаанбаатараас мордов.

Монгол Улсаас Бүгд Найрамдах Энэтхэг Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Т. Чимэддорж БНЭУ-ын Ерөнхийлөгч Ш. Д. Шармад энэ сарын 17-нд итгэмжлэх жуух бичгээ барив.

**1994. 02. 24.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр БНЭУ-ын Ерөнхийлөгчийн ордонд хэд хэдэн гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурав.

**1994. 02. 25.** МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Б. Даш-Ёндон Японы Засгийн газрын урилгаар Японд айлчлахаар явав.

**1994. 02. 25.** Тайландын Ерөнхий сайд албан ёсны уулзалт ярилцлагын дараа Тайландын Засгийн газраас Монголд хүнсний хомсдолыг даван туулах болон байгалийн гамшигт нэрвэгдсэн баруун гурван аймагт хоол хүнсээр туслах зорилгоор хоёр сая батын /өнөөдрийн ханшаар нэг ам. доллар 25,15 баттай тэнцэнэ/ буцалтгүй

тусламж үзүүлснийг мэдэгдэж Ерөнхийлөгч П.Очирбатад чек гардууллаа.

**1994. 02. 28.** БНАЛАУ-ын Ерөнхийлөгчийн “Алтан Ордон”-д хоёр улсын ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат, Нухак Пумсаван нар хэлэлцээ хийлээ.

**1994. 03. 03.** Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат, БНСВУ-ын дарга Ле Дык Ань нар Вьетнамын Төрийн ордонд хэлэлцээ хийлээ.

**1994. 03. 8-9.** Эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Финляндын комиссын Ү хуралдаан Хельсинк хотноо болов.

**1994. 03. 10.** Японы техникийн хамтын ажиллагааны хүрээнд таван жилд багтаан хэрэгжүүлэх “Монголын геологийн алба” төслийн эцсийн баримт бичигт хоёр тал Улаанбаатарт гарын үсэг зурлаа.

**1994. 03. 17.** Олон улсын хөдөлмөрийн байгууллагын /ОУХБ/ Бээжин дэх товчооны захирал Ж. Груа тэргүүтэй төлөөлөгчид манай оронд арав хоног ажиллахаар ирэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Р. Совд тэргүүтэй цэцийн төлөөлөгчид Румын улс, Бүгд Найрамдах Польш Улсын Үндсэн хуулийн шүүхийн урилгаар тэдгээр орны Үндсэн хуулийн шүүхийн туршлагыг судлах ажлаар явав.

Оросын Холбооны Улсын Төрийн Думын дарга И. П. Рыбкин Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Н.Мишигдоржийг хүлээн авч уулзаж, хоёр орны болон парламент хоорондын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

**1994. 03. 22.** Монгол Улсын шадар сайд Л. Энэбиш Бүгд Найрамдах Унгар улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бельгийн Вант Улсад айлчлахаар мордов.

ОХУ-ын Дээд шүүхийн урилгаар Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д. Дэмбэрэлцэрэн тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-д айлчлахаар явлаа.

**1994. 03. 26.** Америкийн сэтгүүлч Рон Глукмен Калифорнийн Венец хэмээх хотхонд “Улаанбаатарын дуу хоолой” гэдэг нэртэй сэтгүүл гаргажээ.

**1994. 03. 31.** Монгол Улсын Шинжлэх ухаан, боловсролын сайд доктор, профессор Н. Өлзийхутаг тэргүүтэй төлөөлөгчид Унгар,

Чех, Турк, ОХУ-тай шинжлэх ухаан, боловсролын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулахаар явлаа.

**1994. 04. 08.** Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрай ОХУ-ын Гадаадтай эдийн засгийн талаар харилцах яамны нэгдүгээр орлогч сайд М. Е. Фрадков тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

**1994. 04. 06.** БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч бөгөөд Гадаад хэргийн сайд Цянь Цичэний урилгаар Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн БНХАУ-д албан ёсны айлчлал хийхээр Улаанбаатараас мордов.

**1994. 04. 16.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар манай оронд албан ёсны айлчлал хийхээр Австралийн Холбооны Улсын Амбан захирагч Билл Хэйдэн гэргий, дагалдан яваа хүмүүсийн хамт Улаанбаатарт хүрэлцэн ирлээ.

**1994. 04. 21.** Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны “Цахиур” компани Шведийн “Вите”, “Овежо”, Австралийн “Айдав” фирмүүдтэй хамтран Дундговь аймгийн Дэрэм суманд гүний худаг гаргахаар усны хайгуулын судалгаа явуулж эхэллээ.

**1994. 04. 25.** Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат АНУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д. Жонсоныг өөрийн нь хүсэлтээр хүлээн авч хоёр орны харилцаны зарим асуудлаар санал солилцов.

**1994. 04. 28.** Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрайн урилгаар манай оронд албан ёсны айлчлал хийхээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн гэргий, дагалдан яваа хүмүүсийн хамт Улаанбаатар хотноо хүрэлцэн ирлээ.

**1994. 04. 29.** Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрай БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн нар Төрийн ордонд хэлэлцээ хийв.

**1994. 05. 06.** Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрай НҮБ ын Глобал технологийн хэсгийн дарга, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн шинжлэх ухаан, технологийн ерөнхий зөвлөх Йозеф Бендакийг хүлээн авч уулзав.

**1994. 05. 09.** Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат Их Британий “Скай , Ньюс” телекомпанийн сурвалжлагч Давид Пейтертэй ярилцав.

**1994. 05. 03-14.** Гадаад харилцааны дэд сайд Ж. Чойнхор Ерөнхийлөгчийн бие төлөөлөгчөөр Индонез, Филиппинд, Ерөнхий сайдын бие төлөөлөгчөөр Сингапур, Малайзад айлчлав.

**1994. 05. 13.** Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат бүх нийтийн тэгш эрхтэй чөлөөт сонгуульд Африк Үндэсний Конгресс ялалт байгуулж ӨАБНУ-ын Үндэсний Ассамблейгаас ӨАБНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон АҮК-ын дарга Нельсон Манделлад баяр хүргэж цахилгаан утас илгээв.

**1994. 05. 18.** Швейцарийн Кредит Сюисс банкны Ази, Номхон далайн орнуудын асуудал эрхлэх удирдлагын гишүүн ноён Р. Зиммерман, мөн банкны Бээжин дэх төлөөлөгч, доктор У. Бухман нар банк хоорондын хамтын ажиллагааны шугамаар манай оронд ирэв.

**1994. 05. 20.** Монголын Социал-Демократ намын дарга, Улсын Их хурлын гишүүн Р. Гончигдорж, Намын дэд дарга Л. Бямбажаргал нар “Ази, Номхон далайн бүсийн ардчилал, эдийн засаг, нийгмийн хөгжил” сэдвээр Токио хотноо болсон Социалист Интернационалын зөвлөлдөх уулзалтанд оролцов.

**1994. 05. 21.** Монгол улсын Ерөнхийлөгч П.Очирбат манай оронд айлчилж буй Австрийн Бүгд Найрамдах Улсын Ерөнхий прокурор Отто Ф. Мюллерийг Төрийн ордонд хүлээн авч уулзав.

**1994. 05. 24.** Английн “Мидлэнд” банкны Ази, Номхон далайн бүс нутгийн асуудал хариуцсан захирал Петер Март Ардын банкны урилгаар манай оронд ирэв.

**1994. 05. 25.** Монгол улс, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын хооронд НҮБ-ын дүрмийн болон олон улсын хууль зүйн бусад зарчмын үндсэн дээр найрсаг харилцааг хөгжүүлэх, хамтран ажиллах эрмэлзлийг удирдлага болгон 1994 оны тавдугаар сарын 25-ны өдрөөс элчин сайдын хэмжээнд дипломат харилцаа тогтоохоор хоёр тал шийдвэрлэв.

**1994. 05. 26.** Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрай Индонезийн парламентын дэд дарга Соержади тэргүүтэй төлөвлөгчдийг хүлээн авч уулзав.

**1994. 05. 31.** Японы монголч эрдэмтдийн зуны их хурал Токиогийн Кандагийн Сэнпү их сургууль дээр болов.